

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/171/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Гэрэлмаа
Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 90

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар амралтын цалин давхардуулан илүү олгосон, урьдчилгаа суутгаагүй, авлагаар тусгаагүй, шатахууныг анхан шатны нотлох баримтгүй зарцуулсан, тайлант онд өр төлбөр үүсгэсэн, шүүхийн шийдвэртэй авлагыг барагдуулаагүй, бэлтгэн нийлүүлсэн бараа, ажил үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын баримтгүй ажил гүйлгээг хийсэн зэрэг 232,346.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2-т Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

0702900314

Тайлант онд Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ой зохион байгуулсан бөгөөд Туульсын хаан жангар, малчдын чуулга уулзалт, алтайн түншлэл-88 зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 18,990.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 366,304.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч, 43,070.8 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 6 хөтөлбөр, 23 зорилт, 125 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 100 арга хэмжээг бүрэн, 14 арга хэмжээг 90.0 хувь, 11 арга хэмжээг 70.0 хувь буюу нийт дүнгээр 96.1 хувиар биелэлтийг гарган Засаг даргад хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	295,880.1	938,309.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,431,684.8	6,018,364.9
Нийт хөрөнгийн дүн	6,727,564.9	6,956,674.5
Нийт өр төлбөрийн дүн	-	68,895.7
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,727,564.9	6,887,778.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,727,564.9	6,956,674.5
Үйл ажиллагааны орлогын дүн	8,379,059.4	6,144,810.2
Үйл ажиллагааны зардлын дүн	4,111,913.9	5,611,373.9
Үйл ажиллагааны үр дүн	4,267,145.5	533,436.2
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	4,218,900.5	160,213.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	2,508,664.4	6,727,564.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,508,664.4	6,727,564.9
Тайлант оны үр дүн	4,218,900.5	160,213.9
Эцсийн үлдэгдэл	6,727,564.9	6,887,778.8
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,925,691.8	5,571,306.4
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,890,279.8	5,508,928.4
Үйл ажиллагааны ЦМГ	35,412.0	62,378.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(35,412.0)	(62,378.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан	-	-
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,669,975.7	4,975,773.0
Урсгал зардал	2,669,975.7	4,975,773.0
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,792,186.4	4,979,076.3
Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,767,867.5	4,857,972.2
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,318.9	3,303.3

Гурав. Аудитын илрүүлэлт:


Аудитын илрүүлэлт

Аудитаар 213,292.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үнэ төлбөргүй авсан орлогыг 1,937.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Тайлант үеийн үр дүнг 4,624.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.



- Түлш халаалтын зардлыг 50,318.4 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 13,791.4 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 4,784.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.
- Үндсэн хөрөнгө худалдсаны гарзыг 6,563.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Хөрөнгө худалдан авсан зардлыг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлаар тайлагнаагүй.
- Урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 68,895.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 232,346.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 232,34.6 мянган төгрөгийн 12 зөрчил² илэрч 6,541.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 225,805.0 мянган төгрөгийн 8 зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 245.9 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Засаг даргын зөвлөх ажиллуулан 6,195.7 мянган төгрөгийн цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно", 5.3-т "Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын зөвлөхөд олгосон цалинг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3. Ажилчдад олгосон цалингийн урьдчилгаа 100.0 мянган төгрөгийг суутгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй , эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалингийн урьдчилгааг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас ЗДТГ-ын хүндэт өргөмжлөлөөр иргэдийг шагнахад нийт 480.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй , эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.


Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

2. Томилолтын удирдамж, хөтөлбөргүй албан томилолтоор ажиллаж 5,075.8 мянган төгрөгийн замын зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1.-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" гэж заасантай нийцэхгүй , эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн хөтлөн шатахууны зарцуулалтад хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

3. Шатахууны зардлыг түүвэрлэн үзэхэд албан томилолт удирдамжгүйгээр 7,908.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1.-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" гэж заасантай нийцэхгүй , эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн хөтлөн шатахууны зарцуулалтад



хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

4. Байгууллага хоорондын маргааныг шийдвэрлэхэд өмгөөлөгчийн хөлсөнд нийт 16,350.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 5,144.0 мянган төгрөг, шатахууны зардал 3,920.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

5. Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 2,700.0 мянган төгрөгийн хувцас, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 6,255.2 мянган төгрөгийн багаж хэрэгслийг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтын "Байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчид голдуу хагас болон бүтэн жилийн эцэст нэг удаа олгох мөнгөн шагнал, урамшуулал, эсхүл журамд заасан нөхцөлөөр олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардал энд хамаарна." "Гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авахад төлөх энэ бүлэг (2108)-т зааснаас бусад ажил, үйлчилгээний төлбөр хураамжууд энд хамаарна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

6. Ажлаас чөлөөлөгдсөн 5 ажилтанд амралтын цалингийн дуусгалтын тооцоо хийгээгүй байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна", 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох; ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудтай дуусгалтын тооцоо хийх албан шаардлага хүргүүлсэн.



7. Данс бүртгэлд нэгээс дээш жилийн насжилттай 109,076.0 мянган төгрөгийн авлага байгаагаас шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын 57,592.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн шийдвэрийн авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлсэн.

8. Тайлант онд 68,895.8 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага үүсч тээвэр шатахуун, халаалт, албан томилолтын өртэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн Засаг даргын тамгын газар	6	213.3	-	-	6	213.3	6	213.3	-	-	-	-
Дүн	6	213.3	-	-	6	213.3	6	213.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аймгийн Засаг даргын тамгын газар	12	225.8	3	6.5	9	219.3	-	-	-	-	-	-
Дүн	12	225.8	3	6.5	9	219.3	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Аймгийн Засаг даргын тамгын газар	1	-	-	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Аймгийн Засаг даргын тамгын газар	6	800.8	-	-	5	560.8	1	240.0		
Дүн	6	800.8	-	-	5	560.8	1	240.0		
Нийт дүн	7	800.8	-	-	5	560.8	2	240.0		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл



№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		